

Бугат сумын Суурь боловсролын сургуульд төлөвлөгөөт  
бус хяналт шалгалт хийсэн тухай танилцуулга

**НЭГ. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН ЗОРИЛГО**

Булган аймгийн Засаг даргын 2017 оны 12 сарын 27-ны өдрийн А/652 дугаар Бугат сумын сургуулийн үйл ажиллагаанд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх ажлын хэсэг байгуулах тухай захирамжийн дагуу хяналт шалгалт хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний санал боловсруулж, үнэлэлт дүгнэлт өгөхөд чигдэгдлээ.

**ХОЁР. ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН БҮРЭЛДЭХҮҮН, ХУГАЦАА**

Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Ж.Оюун

2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрөөс ажлын 10 хоног

**ГУРАВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН БАЙГУУЛЛАГА,  
ОБЪЕКТЫН НЭР**

Бугат сумын суурь боловсролын сургуулийн 2017 оны 04-12 саруудын санхүү, аж ахуйн үйл ажиллагааны баримт материалаас удирдамжид заагдсан асуудалтай холбоотой баримт материалыг түүвэрчлэн шалгав.

**ДӨРӨВ. ШАЛГАЛТАНД ХАМРАГДСАН АСУУДАЛ**

1. Ур чадварын нэмэгдэл олгосон байдал, цалин хөлсний суутгал
2. Сургуулийн удирдлага, багш, ажиллагсдын ажлын цаг ашиглалтын байдал
3. Хүнс, бараа материал бэлтгэсэн байдал
4. “Эх хэл эрхэм баян” бага ангийн монгол хэлний кабинетийн үйл ажиллагааг сайжруулах төслийн гүйцэтгэл
5. 2017 оны төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийн байдал

**ТАВ. ШАЛГАЛТЫН ЯВЦАД ХИЙГДСЭН АЖИЛ,  
ШИЙДВЭРЛЭСЭН АСУУДАЛ**

Бугат сумын суурь боловсролын сургуулийн 2017 оны 4-12 сарын касс, харилцахын баримт, захирлын тушаал, хүнс, бараа материалын тайлан, үндсэн хөрөнгө хүнс, бараа материалын орлогын падааны жагсаалт, цалин олгох хүснэгт, багш нарын болон захиргаа аж ахуйн ажилчдын цагийн бүртгэл, тус сургуулийн баш, ажиллагсдын болон захирлын дэргэдэх зөвлөлийн хурлын тэмдэглэл, төсөвт байгууллагуудын 2016-2017, 2017-2018 онд хэрэглэх хүнс, бараа материал нийлүүлэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл, холбогдох материал, “Эх хэл эрхэм баян” төслийн зарцуулалт, тус сургуулийн 2014 оны 01 сарын 06-ны өдрийн багш хамт олны хурлаар баталсан “Хөдөлмөрийн дотоод журам” зэрэг баримт материалуудад тулгуурлан захирал Б.Ариунтунгалаг, Сургалтын менежер Л.Соёл-Эрдэнэ, номын санч, бичиг хэргийн ажилтан М.Оюунтуяа, нягтлан бодогч Б.Дагийсүрэн, нярав Х.Галбадрах нараас тайлбар тодруулга авч, холбогдох баримт материалуудыг хуулбарлаж авлаа.

Тус сургуулийн санхүү, аж ахуйн үйл ажиллагаанд 1-р гарын үсгийг 01 сарын 01-ээс 03 сарын 29-ний өдрийг хүртэл захирал Х.Тамжид, 03 сарын 30-аас 12 сарын 31-ний өдрийг дуустал захирал Б.Ариунтунгалаг, 2-р гарын үсгийг 01 сарын 01-ээс 07 сарын 31-ний өдрийг хүртэл нягтлан бодогч С.Нямсүрэн, 08 сарын 01-ээс 12 сарын 31-ний өдрийг дуустал нягтлан бодогч Б.Дагийсүрэн нар зурсан ба сумын төрийн сангийн 100040215101 тоот,

нэмэлт санхүүжилтийн 100040215401 тоот данстайгаар хөрөнгө мөнгийг захиран зарцуулж ирсэн байна.

#### **4.1 а) Багш, ажиллагсдад олгосон үр чадварын нэмэгдлийн талаар:**

Тус Суурь боловсролын сургууль нь 4-12 сард багш, ажилчдын хурлыг 04 сарын 18-нд 1 удаа, байгууллагын хөдөлмөрийн дотоод журмын 2.3-д заасан захирлын дэргэдэх зөвлөл нь 04 сарын 17, 26, 05 сарын 22, 06 сарын 21, 07 сарын 24, 09 сарын 26, 10 сарын 26, 11 сарын 23, 12 сарын 14-нд нийт 9 удаа үр чадварын нэмэгдэл олгох эсэх асуудлаар хуралдаж, шийдвэрлэсэн байна.

Уг шийдвэрийн дагуу сургуулийн захирлын тушаалуудыг үндэслэн багш, ажиллагсдад үндсэн цалингийн 15-60 хувиар тооцож нийтдээ 31 хүнд 10496.7 мянган төгрөгийн үр чадварын нэмэгдэл олгосон байна. Үүнд:

*4-р сард:* Сургуулийн захирлын 2017 оны 04 сарын 18-ны Б/23, 04 сарын 27-ны Б/24, Б/25 дугаар тушаалуудыг үндэслэн гадаад хэлний багш И.Ичинхорлоогийн шавь М.Сарангэрэл нь аймагт зохиогдсон гадаад хэлний “Мини” олимпиадад гадаад дууны төрөлд 2-р байр эзэлж мөнгөн медаль хүртсэнд багшид 20%, бага ангийн багш Г.Хажидмаад Сэлэнгэ суманд зохиогдсон зүүн бүсийн Ц.Гомбожавын нэрэмжит “Сайн хичээл” үйл ажиллагаанд амжилттай оролцож 1-р байр эзэлсэнд 10%, сахиул-мужаанч В.Соронзонболдод өөрийн хариуцсан ажлаа тогтмол сайн гүйцэтгэн, идэвхи санаачлага гарган үр дүнтэй ажилласанд 25%-иар,

*5-р сард:* Сахиул-мужаанч В.Соронзонболдод 25%-иар

*6-р сард:* Сургуулийн захирлын 05 сарын 24-ний Б/31 дүгээр тушаалаар хүүхдийн сургалт хүмүүжлийн ажилд нэвтрүүлсэн шинэлэг ажил, хөгжил төлөвшилд гаргасан ахиц, бүтээлч хандлага, ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэхэд идэвхи санаачлага гарган суралцагчдад байгалийн ухааны туршилтын талбайг байгуулахад үр бүтээлтэй ажилласан гэж бага ангийн багш М.Оюунчимэгт 15%, багш Г.Оюунгэрэл, Ц.Баатарчулуун, И.Ичинхорлоо, Б.Цэрэннадмид, сургалтын менежер Л.Соёл-Эрдэнэ нарт тус бүр 30%, нягтлан бодогч С.Нямсүрэн, номын санч АБХАжилтан М.Оюунтуяа, нярав Х.Галбадрах, сантехникч, слесарь Д.Эрдэнэзаяа, сахиул мужаан В.Соронзонболд нарт тус бүр 25%-иар,

*7-р сард:* - Сургуулийн захирлын 06 сарын 22-ны Б/36 дугаар тушаалаар хүүхдийн сурах орчныг сайжруулах, хүүхдийн хөдөлмөр зусланг байгуулах ажлыг эхлүүлэхэд идэвхи санаачлага гарган ажилласан, өөрийн хариуцсан ажлаа үр дүнтэй хийж гүйцэтгэсэн гэж сургалтын менежер Л.Соёл-Эрдэнэ, нийгмийн ажилтан Э.Пүрэвсүрэн нарт тус бүр 30%, номын санч АБХАжилтан М.Оюунтуяа, нярав Х.Галбадрах, сантехникч-слесарь Д.Эрдэнэзаяа, сахиул-мужаан В.Соронзонболд, жижүүр О.Осорбарам нарт тус бүр 25%-иар мөн 07 сарын 24-ний Б/38 дугаар тушаалаар хүүхдийн сурах орчныг сайжруулах, хүүхдийн хөдөлмөр зуслантай болох ажилд идэвхитэй оролцож сэргээн засварлаж дуусгасан, орон нутагт явагдсан А.Амар сайдын түүхэн кино зураг авалтын арын ажлыг хангалттай сайн хийж гүйцэтгэсэн гэж номын санч АБХАжилтан М.Оюунтуяа, нярав Х.Галбадрах, сантехникч-слесарь Д.Эрдэнэзаяа, сахиул-мужаан В.Соронзонболд, жижүүр О.Осорбарам нарт тус бүр 25%-иар,

*9-р сард:* Сургуулийн захирлын 09 сарын 26-ны Б/56 дугаар тушаалаар хүүхдийн сургалт хүмүүжлийн ажилд нэвтрүүлсэн шинэлэг ажил, хөгжил төлөвшилд гаргасан ахиц, бүтээлчээр ажиллаж идэвхи санаачлага гарган ажилласан гэж сургалтын менежер Л.Соёл-Эрдэнэд 30%, үйлчлэгч Б.Мөнхцэцэгт 25%-иар,

*10-р сард:* Сургуулийн захирлын 10 сарын 27-ны Б/59 дүгээр тушаалаар хүүхдийн сургалт хүмүүжлийн ажилд нэвтрүүлсэн шинэлэг ажил, хөгжил төлөвшилд гаргасан ахиц, бүтээлчээр ажиллан бусаддаа үлгэрлэн идэвхи санаачлага гарган ажилласан гэж сургалтын менежер Л.Соёл-Эрдэнэ, физик математикийн багш А.Гантөр нарт тус бүр 30%, номын санч АБХАжилтан М.Оюунтуяа, сахиул-мужаан В.Соронзонболд, үйлчлэгч Б.Мөнхцэцэг нарт тус бүр 25%-иар,

*11-р сард:* - Сургуулийн захирлын 11 сарын 24-ний Б/60, Б/61, Б/63 дугаар тушаалуудыг үндэслэн Хишиг-Өндөр суманд зохиогдсон Ш.Гаадамбын нэрэмжит “Эх хэл”-ний олимпиадад бэлтгэсэн сурагчид нь амжилттай оролцож 1-р байр эзэлсэнд багш Б.Думаа, Б.Цэрэннадмид нарт 20%, “Эх хэл”-ний олимпиадад оролцсон сурагцагчдын хувцас, “Бидний гоёл-Үнсгэлжин-2018” загварын тэмцээнд оролцох 3 коллекцийн 9 загварын хувцасыг хийхэд хамтран ажилласан, дотуур байрны гаднах доторх орчин, гал тогооны өрөө, тасаг байрыг сэргээн засварласан, өөрийн хариуцсан ажилдаа идэвхи санаачлагатай ажилласан, “Бидний гоёл-Үнсгэлжин-2018” загварын тэмцээнд багш, сурагчид амжилттай оролцож удирдагч багшаар 2-р байр, гоёлын загвараар 5-р байр, үндэсний хувцасны загварын төрөлд 3-р байрыг эзэлсэн, суралцагчдын авъяас чадварыг нээн хөгжүүлсэн гэж сургалтын менежер Л.Соёл-Эрдэнэ, багш И.Ичинхорлоо, Б.Аюурзана, Б.Ганням, Д.Эрдэнэбулган, Б.Батмаа нарт тус бүр 30%, сахиул-мужаан В.Соронзонболд, жижүүр О.Осорбарам нарт тус бүр 25%, Биеийн тамирын багш П.Баярсайханы дасгалжуулсан шавь Б.Далхсүрэн нь Улаанбаатор хотод зохиогдсон УАШалгаруулах гүйлтийн цанын төрөлд 1-р байр эдэлж, алтан медаль хүртсэнд 11, 12 сард 25%-иар,

*12-р сард:* - Сургуулийн захирлын 11 сарын 24-ний Б/68 дугаар тушаалаар хүүхдийн сурч хөгжүүлэхэд хувь нэмэр оруулан төр, төсвийн байгууллагуудын дунд зохиогдсон уралдаан тэмцээнд идэвхитэй оролцож тэргүүн байр эзэлсэн, дотуур байрны хүүхдийн амьдрах орчин нөхцөлийг сайжруулан суралцагчдыг урлагийн үзлэгт идэвхитэй оролцуулж авъяас чадварыг нээн хөгжүүлж зохион байгуулсан, аймгийн багш нарын уралдаан тэмцээнд амжилттай оролцож тэргүүн байр эзэлсэн, суралцагчдын сурах орчныг тохижуулан идэвхи санаачлага гарган ажилласан гэж бага ангийн багш Б.Думаа, Г.Хажидмаа нарт 60%, багш Ц.Баатарчулуун, М.Оюунчимэг, нийгмийн ажилтан Г.Гансоёмбо, сантехникч-слесарь Д.Эрдэнэзаяа, тогооч Л.Оюунцэцэг, Б.Хишгээ нарт 50%, нярав Х.Галбадрах, номын санч АБХАжилтан М.Оюунтуяа нарт 40%, сургалтын менежер Л.Соёл-Эрдэнэ, багш И.Ичинхорлоо, Б.Аюурзана, Б.Ганням, А.Гантөр, Г.Оюунгэрэл, Б.Батмаа нарт 30%, ня-бо Б.Дагийсүрэн, сахиул мужаан В.Соронзонболд, жижүүр О.Сосорбарам, Б.Мөнхцэцэг нарт 25%, багш Д.Эрдэнэбулган, Ө.Ганчимэг, Б.Цэрэннадмид, дотуур байрны багш Н.Пүрэвдаш, жижүүр Б.Мөнхтуяа, үйлчлэгч Б.Нарангэрэл, С.Должиндулам нарт 20%-иар тус тус ур чадварын нэмэгдэл олгосон байна.

#### **б) Цалин хөлсний суутгал:**

Тайлант оны 4-12 сард тус сургуулийн удирдлага, багш, ажиллагсдын цалин хөлснөөс ЭМНДШимтгэлд 24143.9 мянган төгрөг, ХХОАТатварт 19103.6 мянган төгрөг, цалингийн урьдчилгаанд 19670.0 мянган төгрөг, хуримтлалд 1108.8 мянган төгрөг, шүүхийн шийдвэрийн дагуу 1 ажилтанаас 1100.0 мянган төгрөг нийт 65126.3 мянган төгрөг суутгасан байна.

#### **4.2 Цагийн бүртгэл хөтлөлтийн талаар:**

Багш нарын цагийг жижүүр багш “жижүүр багшийн дэвтэр”, захиргаа аж ахуйн ажилчдын цагийг 4,5 сард үйлчлэгч Б.Мөнхуяа, 6-12 сард номын санч-архив бичиг хэргийн

ажилтан “цагийн бүртгэл” гэсэн компьютерт шивж бэлтгэсэн дэвтэрээр бүртгэж хөтөлсөн байна. Жижүүр багш нар багшийн цагийг ирсэн, явсан цаг минутаар нь бүртгэсэн ба цаг бүртгэгч нар захиргаа, аж ахуйн ажилчдын цагийг 9<sup>00</sup>-13<sup>00</sup>, 13<sup>00</sup>-14<sup>00</sup>, 14<sup>00</sup>-18<sup>00</sup> гэж бүртгэсэн, албан томилолтоор ажилласан ажилтныг ажилдаа ирсэнээр бүртгэсэн байна.

Захирал Б.Ариунтунгалаг нь 2017 оны 04 сарын 28-30, 05 сарын 19, 27, 09 сарын 16-17, 10 сарын 05, 11 сарын 15-19, 12 сарын 08-09-ний өдрүүдэд нийт 7 удаа буюу 15 хоног ОХУ руу зорчсон ба үүний 8 хоног нь долоо хоногийн амралтын өдөр, 7 хоног нь ажлын өдөр байна.

Ажлын 7 өдрийг задалж авч үзвэл: Захирал Б.Ариунтунгалаг нь 04 сарын 28-нд Булган аймагт “Хөгжлийн хөтөч” хөтөлбөрийн нээлтийн үйл ажиллагаанд оролцсон (албан томилолтын үнэмлэхтэй), 10 сарын 05-нд сумын Засаг даргаас 1 өдрийн чөлөө авсан, 11 сарын 15-17-нд сумын Засаг даргын 2017 оны 11 сарын 15-ны өдрийн А/127 дугаар “ОХУ-ын Закаемский аймаг руу явах албан хаагчдыг томилох тухай” захирамжийн дагуу тус аймгийн хамтын үйл ажиллагаатай танилцах, туршлага судлахаар томилогдон ажилласан (албан томилолтын үнэмлэхгүй) байна. 05 сарын 19, 12 сарын 08-ны өдрүүдэд 09 цагаас 18 цаг хүртэл бүтэн ажилласнаар цагийн бүртгэлд бүртгэлтэй байна.

#### **4.3 Хүнс, бараа материал бэлтгэсэн байдал:**

Сумын Засаг даргын 2016 оны 09 сарын 19-ний А/156 дугаар захирамжаар төсөвт байгууллагуудын 2016-2017 онд хэрэглэх хүнсний бүтээгдэхүүнийг нийлүүлэх, 2017 оны 10 сарын 05-ны А/108 дугаар захирамжаар төсөвт байгууллагуудын 2017-2018 онд хэрэглэх хүнс, бараа материал нийлүүлэх ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын хэсгийг байгуулсан байна.

Ажлын хэсэг 2016 оны 09 сарын 29-ний өдөр хуралдаж төсөвт байгууллагуудад 2016-2017 онд “Малчин заяа бүлэг” мах, Бугат Ариг ХХК хүнсний бүтээгдэхүүн нийлүүлэх, 2017 оны 10 сарын 20-ны өдрийн ажлын хэсгийн хурлаар төсөвт байгууллагуудад 2017-2018 онд малчин Л.Санжаа хонь, үхрийн мах, малчин П.Нямдорж сүү, тараг, аарц нийлүүлэхээр сонгон шалгаруулж, бусад хүнс, төмс хүнсний ногоо, бараа бүтээгдэхүүнийг шууд гэрээ байгуулан нийлүүлэхээр эрхийг байгууллагын удирдлагад шилжүүлсэн байна.

Үүний дагуу Маргад-Орхон ХХК, Бугат Ариг ХХК, Малчин заяа бүлэг, малчин Л.Санжаа, П.Нямдорж нартай гэрээ байгуулан хүнс, бараа материал худалдан авч, үүнээс бусад хүнс, бараа материал нийлүүлсэн иргэн, аж ахуйн нэгж байгууллагатай сонгон шалгаруулалт, гэрээ байгуулаагүйгээр шууд худалдан авалт хийсэн байна.

Тайлант оны 4-12 сард дараахи иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийсэн байна. Үүнд: тус сумын Бугат Ариг ХХК, Маргад Орхон ХХК, Сиб ХХК, Элгэн бугат фарм, Шунхлайпетролиум, иргэн Л.Санжаа, Б.Мөнхцэцэг, Ц.Оюунтуяа, Б.Мөнхбат, П.Нямдорж, тус байгууллагын цахилгаанчин слесарь Д.Эрдэнэзаяа, Орхон аймгийн Түмэн үзэг ХХК, Номиндорж ХХК, Тод өнгө ХХК, Даниста ХХК, Гүрсоронзон ХХК, Монгол шуудан, БСБ электроникс, Саммит компьютер технологи ХХК, Си Ти Эс ХХК, иргэн Б.Бадамжав, Ш.Бадамханд, С.Отгонбаяр, Ч.Мягмарсүрэн, Д.Мандал, М.Сайнжаргал, Г.Гансүх, Ж.Эрдэнэсайхан, М.Хишигжаргал, Я.Саранцэцэг нараас 19614.2 мянган төгрөгөөр хүнс, 27693.3 мянган төгрөгөөр хангамж аж ахуйн материал, 79.1 мянган төгрөгөөр эм, 16113.1 мянган төгрөгөөр үндсэн хөрөнгө бэлтгэж, тайлан балансад тусгасан байна.

БСШУЯ-аас 3013.2 мянган төгрөгийн үнэ бүхий бага ангийн STEM-ийн сургалтын хэрэглэгдэхүүн, 8440.4 мянган төгрөгийн үнэ бүхий сүлжээний тоног төхөөрөмж, 9004.8 мянган төгрөгийн тавилга эд хогшил, БСУГазраас 178.9 мянган төгрөгийн үнэ бүхий 1-5-р

ангийн сурах бичиг, иргэний хандиваар 2354.0 мянган төгрөгөөр гэр, ногоон дроз үнэ төлбөргүйгээр өгснийг тайланд орлогодсон байна.

Дээрх худалдан авалтаас гадна “Кик бокс”, “Сайн хичээл”, “Эх хэл”, “Бидний гоёл-Үнсгэлжин 2018” зэрэг олимпиад, уралдаан тэмцээн, 2016-2017 оны хичээлийн жилд сурлага, урлаг, спортоор амжилт гаргасан багш сурагчдыг урамшуулах, ахмадын баяраар ахмадад хүндэтгэл үзүүлэх, байгалийн ухааны туршилтын талбайн үрсэлгээний үнэнд, 2017-2018 оны хичээлийн жилд ОХУ-ын Закаменский хотын удирдлага, сургуультай уулзах уулзалт, мөн “Эх хэл эрхэм баян” төслийн хүрээнд Бугат Ариг ХХК, Маргад Орхон ХХК, иргэн Д.Баасантуяа, Орхон аймгийн Есөн Эрдэнэ зах, Эрдэнэт бөөний төв, иргэн Г.Цогзолмаа нараас 2484.2 мянган төгрөгөөр хүнс, бараа материал бэлтгэсэн ч няравын тайлангаар дамжуулалгүй шууд зарцуулсан байна.

#### 4.4 “Эх хэл эрхэм баян” бага ангийн монгол хэлний кабинетийн үйл ажиллагааг сайжруулах төслийн гүйцэтгэлийн талаар:

Бугат сумын А.Амарын нэрэмжит суурь боловсролын сургуулийн сургалтын менежер, бага ангийн ЗАН-ийн багш нар хамтарч 2017 оны 04 сард Дэлхийн банк, БСШУЯ-аас хэрэгжиж буй “Боловсролын чанарын шинэчлэл” сургуулийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд “Эх хэл эрхэм баян” төслийг бичсэн байна.

Уг төслөөр бага ангийн “Эх хэл”-ний кабинетийг байгуулахаар 11 ажлыг төлөвлөж, үүний зардал болох сургалтын хэрэглэгдэхүүн, бусад материалын худалдан авалтын зардалд 3096.4 мянган төгрөг, сургалт-уулзалтын зардалд 1210.0 мянган төгрөг, үйл ажиллагааны зардалд 493.6 мянган төгрөг нийт 4800.0 мянган төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Төсөл дэмжигдэж, 2017 оны 09 сард нэмэлт санхүүжилтийн дансаар төслийн 4800.0 мянган төгрөгийн санхүүжилтээс 3840.0 мянган төгрөг ирж, үүнээс тайлант онд **3053.9** мянган төгрөгийг зарцуулж, дараа онд хэрэгжих болон тайлант онд хэрэгжээгүй ажил болох монгол хэлний зөв бичих дүрмийн сургалтын зардал 135.0 мянган төгрөг, цахим хичээлийн сан бий болгох зардлын 186.0 мянган төгрөг нийт 321.0 мянган төгрөгийг сургалтын менежер Л.Соёл- Эрдэнэд бэлнээр өгсөн, дараа онд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 4 ажлын зардал 354.1 мянган төгрөгийг сургалтын менежер Л.Соёл-Эрдэнэ, бага ангийн багш Г.Хажидмаа, номын санч-АБХАжилтан М.Оюунтуяа нарт бэлнээр өгч уг мөнгөөр 12 сард Маргад Орхон ХХК-ий дэлгүүрээс чихэвч 3 ш, ширээний гэрэл 6 ш, шоо 6, шал угаагч 1 ш, бишгүүр, үсний сэнс, теннисний бөмбөг ракеттай, дээс тус бүр 2 ш-ийг худалдан авсан, татварт 70.4 мянган төгрөгийг шилжүүлж, үлдэгдэл 40.6 мянган төгрөгийг 2017 оны 12 сарын 26-нд төв төрийн сангийн 100040051499 тоот дансанд төвлөрүүлсэн байна. Тус сургуулийн жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын комисс нь дээрх төслийн хүрээнд зарцуулахаар сургалтын менежерт бэлнээр олгосон бэлэн мөнгө 321.0 мянган төгрөгийг дэвсгэртээр нь тоолж жагсаалт үйлдсэн, дараа онд хэрэгжих ажлын уралдаан тэмцээнд зарцуулахаар авсан бараа материалыг тоолж, тооллогын бүртгэл хөтөлсөн байна.

Төслийн хүрээнд тайлант онд 5, дараа онд 6 нийт 11 ажлыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн ба тайлант онд хэрэгжүүлэх ажлаас 3 нь бүрэн хэрэгжиж, 1 нь хагас, хичээнгүй бичиг, цахим үлгэр хийлгэх ажил хийгдээгүй буюу хэрэгжилт 80 %-тай байна.

Дараа онд хэрэгжүүлэх ажлын удирдамжийг боловсруулан батлуулсан байна.

#### 4.5 2017 оны төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлт:

2017 онд улсын төсвөөс 475836.6 мянган төгрөгийн санхүүжилт, нийгмийн даатгалын сангаас жирэмсэн амаржсаны болон хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийн 4553.7

мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансаар “Өсвөр үеийн цана”-ын улсын аварга шалгаруулах тэмцээнд оролцох баг тамирчдын хоолны зардлын 741.4 мянган төгрөг, “Эх хэл эрхэм баян” төслийн 3840.0 мянган төгрөг бүгд 484971.7 мянган төгрөгийн орлого орсон байна.

Тайлант онд төсөвт зардлыг 475836.6 мянган төгрөгөөр төлөвлөн батлагдсаны дагуу санхүүжилтийг авч, үйл ажиллагааны зардалд 471831.6 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 4005.0 мянган төгрөгийг 2017 оны 12 сарын 26-нд төв төрийн сангийн дансанд татан төвлөрүүлсэн байна.

Зарцуулагдаагүй үлдэгдлийг дэлгэрэнгүй авч үзвэл: цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлаас 625.8 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 50.3 мянган төгрөг, тогтмол зардлаас 3297.3 мянган төгрөг, хангамж бараа материалын зардлаас 1.5 мянган төгрөг, нормативт зардлаас 1.6 мянган төгрөг, эд хогшил урсгал засварын зардлаас 0.7 мянган төгрөг, дотоод албан томилолтын зардлаас 0.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлаас 21.5 мянган төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардлаас 0.5 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 0.5 мянган төгрөг, төрөөс иргэдэд олгох тэтгэмж урамшууллын зардлаас 4.5 мянган төгрөг үлдсэн байна.

#### ЗУРГАА. ШАЛГАЛТААР ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ, ДУТАГДАЛ

1. Тус сургуулийн захирлын дэргэдэх зөвлөлийн бүрэлдэхүүнийг баталсан тушаал гаргаагүй.

2. Захиргаа аж ахуйн ажилчдын цагийг ирсэн, явсан цаг минутаар нь бүртгэдэггүй 09<sup>00</sup>-13<sup>00</sup>, 14<sup>00</sup>-18<sup>00</sup> гэж бүртгэдэг албан томилолтоор ажилласан ажилчдыг ажилдаа ирснээр бүртгэсэн, цалингийн баримтуудад багш, ажиллагсдын гарын үсэг зурагдаагүй.

3. Ур чадварын нэмэгдэл олгохоор гаргасан 2017 оны Б/23, Б/24, Б/25, Б/31, Б/36, Б/38, Б/56, Б/59, Б/60, Б/61, Б/63, Б/68 дугаартай эрх захирагчийн шийдвэрүүдийг шилэн дансны нэгдсэн вэб сайтад мэдээлж байршуулаагүй байна

4. Ур чадварын нэмэгдлийг

- Байгууллага дотооддоо боловсруулж баталсан журамгүй
- Эрх захирагчийн шийдвэргүйгээр сахиулд 5 сард 25 хувиар,
- Нэр бүхий 10 албан хаагчдад 12 сард нэмэгдлийг 40-60 хувиар,
- Аймаг, бүсийн олимпиадад амжилттай оролцож 1, 2 дугаар байр эзэлсэн нэр бүхий 3 багшид хөдөлмөрийн дотоод журмын 8.1.5-д зааснын дагуу 10-15 хувиар олгохоор тусгасан ч 20 хувиар олгосон

- Захирлын дэргэдэх зөвлөлийн 05 сарын 22, 06 сарын 21, 11 сарын 23, 12 сарын 15-ны өдрийн хурлаар ур чадварын нэмэгдлийг “багш, ажилчдад” эсвэл нэр дурьдсан ч “20-30 хувь” гэж хэнд, хэдэн хувиар олгох нь тодорхойгүй

- Байгалийн ухааны туршилтын талбайг байгуулсан, хүүхдийн хөдөлмөр зусланг байгуулах ажлыг эхлүүлэх, сэргээн засварлаж дуусгахад идэвхи санаачлагатай ажилласан, А.Амар сайдын түүхэн киноны зураг авалтын арын ажлыг хангалттай сайн хийсэн, “Эх хэл”-ний олимпиадад оролцсон сурагчдын хувцас, “Бидний гоёл-Үнсгэлжин 2017” тэмцээний загварын хувцас хийхэд хамтарч санаачлагатай ажилласан, сурагчдын авъяас чадварыг нээн хөгжүүлсэн, сургууль, дотуур байрны гаднах доторх орчин, гал тогооны өрөө, тасаг байрыг сэргээн засварласан, өөрийн хариуцсан ажилдаа идэвхи санаачлагатай ажилласан, хүүхдийн сургалт хүмүүжлийн ажилд нэвтрүүлсэн шинэлэг ажил, бүтээлч хандлага,

ажиллах орчин нөхцлийг бүрдүүлэхэд идэвхи чармайлт гарган ажилласан гэх зэргийг үндэслэж тус тус олгосон байна.

5. “Эх хэл эрхэм баян” төслийн хүрээнд нярав Х.Галбадрах 1839.6 мянган төгрөгийг бэлнээр авч үүнээс 70.4 мянган төгрөгийг татварт шилжүүлж, үлдэгдэл 1769.2 мянган төгрөгийг төслийн ахлагч, гишүүд Л.Соёл-Эрдэнэ, Г.Хажидмаа, М.Оюунтуяа нарт бэлнээр тавьж олгосон ч бэлэн мөнгөний орлого, зарлагын баримт үйлдээгүй, бэлнээр олгосон мөнгөнөөс дараа онд хэрэгжих ажлын зардлын 321.0 мянган төгрөг сургалтын менежерт бэлнээр, 354.1 мянган төгрөгөөр бараа материал бэлтгэсэн байна.

#### АВСАН АРГА ХЭМЖЭЭ, МЭРГЭЖИЛ АРГА ЗҮЙН ЗӨВЛӨГӨӨ ӨГСӨН БАЙДАЛ

✓ Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулахаар 6 заалттай 1 албан шаардлага үйлдэв.

✓ Илүү олгосон ур чадварын нэмэгдэл 1186.5 мянган төгрөгийг төлүүлэхээр улсын байцаагчийн акт тогтоов.

✓ Тус сургуулийн захирлын тушаалаар багш, ажилчдад ур чадварын нэмэгдэл олгохоор гаргасан захирлын тушаалуудыг байршуулсан эсэхийг shilendans.gov.mn нэгдсэн вэб сайтаас шалгав.

✓ “Эх хэл эрхэм баян” төслийн хүрээнд дараа онд хэрэгжих ажлын зардал 354.1 мянган төгрөгөөр бэлтгэсэн бараа материал, бэлэн мөнгө 321.0 мянган төгрөг сургалтын менежер, бага ангийн багш, номын санч-бичиг хэргийн ажилтан нар дээр байсныг жагсаалтаар няравт буцаан өгүүлэв.

✓ Байгууллага дотооддоо ур чадварын нэмэгдэл олгох журам боловсруулж мөрдөж ажиллах, дотоод хяналт шалгалт зохион байгуулах, багш ажиллагсдын цагийг ирсэн, явсан цаг минутаар нь үнэн, зөв засваргүй, цагийн бүртгэлийг дэвтэр маягтаар бүртгэж хөтлөх, багш ажилчдын болон захирлын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудал, санал, шүүмжлэл гэх зэргийг бүрэн эхээр нь тэмдэглэж хөтлөх, захирлын тушаалын төслийг архив албан хэрэг хөтлөлтийн журмын дагуу хадгалах талаар холбогдох хүмүүст мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.

#### ДҮГНЭЛТ

✓ Тус сумын сургууль нь 2017 оны 4-12 сард Бугат сум, Орхон аймгийн иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийсэн байна.

✓ Сургуулийн захирал Б.Ариунтунгалаг нь ажлын цагаар ОХУ руу явсан, сургуульд хүнс, бараа материал нийлүүлсэн гэх асуудал анхан шатны баримтаар нотлогдохгүй байна.

✓ Ур чадварын нэмэгдлийг байгууллага дотооддоо боловсруулсан журамгүй, шалгуур үзүүлэлтээр үнэлж дүгнэлгүй захирлын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж шийдвэрлэн, тушаалаар баталгаажуулан 4-7, 9-12 саруудад олгосон байна. Нэр бүхий 10 албан хаагчдад журамд заасан хэмжээнээс 20-30 хувиар илүү тооцож 1093.8 мянган төгрөг, эрх захирагчийн шийдвэргүйгээр 1 ажилтанд 92.7 мянган төгрөг нийт 1186.5 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл илүү олгосон байна.

#### ЦААШИД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ САНАЛ

1. Улсын /ахлах/ байцаагчийн акт, албан шаардлагын хэрэгжилтийг хугацаанд нь биелүүлэх

2. Төсвийн тухай хуулийн 16.5.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1, 13.5, 13.7 дахь заасан заалтууд, Хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 1996 оны 63/104 дугаар тушаалаар баталсан журмын 3, 6, 7, БСШУСайд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд, Сангийн сайдын 2010 оны 362/112/183 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан шалгуур үзүүлэлтийн 3, 4 дэх заалтууд, Сангийн сайдын 2000 оны 69 тоот тушаалаар батлагдсан “Эд хариуцагчийн эрх үүргийн дүрэм”-ийг хэрэгжүүлж ажиллах

3. Шилэн дансанд мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлэх

БИЧСЭН:

САНХҮҮГИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН  
УЛСЫН БАЙЦААГЧ

Ж.ОЮУН



